

Э-Сонин

31 дахь дугаар

Мэдээний Тойм



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

“БИНСЭ” ХК-ИЙН НЭМЖ ГАРГАСАН ҮНЭТ
ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭЛЭЭ



ЗОХИЦУУЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС
БУУРСАН ТАЛААР ДЭЛГЭРЭНГҮЙ
МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ

ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАНА



КАСТОИАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗАХ
ЗЭЭЛД НЭВТЭРЛЭЭ

5,460 ДАНС ШИНЭЭР НЭЭГДЭЖ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН
ИДЭВХ ЭРС НЭМЭГДЖЭЭ



МХБ-ИЙН МОБАЙЛ АППЛЕКЕЙШНЫ 2
ДАХЬ ХУВИЛБАР “APP STORE”-Д
ШИНЭЧЛЭГДЭН ТАВИГДАЖ,
ХЭРЭГЛЭГДЭХЭД БЭЛЭН БОЛЛОО

ЖАЙКА ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГАТАЙ УУЛЗАЛТ,
СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Д.АНГАР: ЭРДЭНЭТ ХОТОД НЭЭЛТТЭЙ
ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛНА

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖУЦ-ны 5 дугаар сарын арилжааны мэдээлэл.
- “Бинсэ” ХК /хуучнаар “Баян хайрхан” ХК/ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа 1.0 сая ширхэг хувьцаа нэмж гаргах тухай шийдвэр гаргав.
- СЗХ-ны тогтоолоор “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоов.
- Жижиг дунд бизнес эрхлэгчдийг хөрөнгийн зах зээлд гаргана.
- Худалдаа хөгжлийн банк кастодианы үйл ажиллагааг албан ёсоор Монголд анх эхлүүлж буйгаа зарлаж, нээлтийн ёслолын үйл ажиллагааг хийлээ.
- 2015 оны эхний 4 сарын байдлаар 5,460 данс шинээр нээгдэж, хөрөнгө оруулагчдын идэвхи эрс нэмэгджээ.
- МХБ-ийн мобайл апплейкешны 2 дахь хувилбар гарлаа.
- Д.Ангар: Эрдэнэт хотод нээлттэй өдөрлөг зохион байгуулна.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 5-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ


“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт”-ыг 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдөр явуулахаар төлөвлөж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 11323715 -116 дугаараас авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны /Нэгжийн үнэ 100,000 төгрөг/ захиалгыг долоо хоног бүрийн Лхагва гарагаас дараа долоо хоногийн Мягмар гараг хүртэл авч, арилжааг зохион байгуулж байна. Тавдугаар сард тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 4 удаа зохион байгуулж нийт 28.5 тэрбум төгрөгийн богино болон урт хугацаат ГЗҮЦ-ыг арилжаалсан байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2015.05.05	ЗГХБ-Б-12-304	12	30,523	14.967%	2,950,658,410.00
2015.05.12	ЗГЭБ-Б-28-305	28	2,437	15.529%	224,942,411.00
2015.05.12	ЗГЭБ-У-156-306	156	185	16.875%	18,500,000.00
2015.05.19	ЗГХБ-Б-12-307	12	255,304	14.90%	24,684,067,240.00
2015.05.26	ЗГЭБ-Б-52-308	52	6,709	15.75%	670,900,000.00
2015.05.26	ЗГЭБ-У-156-309	156	141	16.875%	14,100,000.00
НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ			295,299		28,563,168,061.00



“БИНСЭ” ХК-ИЙН НЭМЖ ГАРГАСАН ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭЛЭЭ



МАЛЫН ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ ТӨВ

“Бинсэ” ХК /хуучнаар “Баян хайрхан” ХК/ нь 2014 оны 10 сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1.0 сая ширхэг хувьцаа нэмж гаргах тухай шийдвэр гаргасан бөгөөд СЗХ-ны 2015 оны 01-р сарын 28-ны өдрийн 70 тоот тогтоолоор тус нэмэлт үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржид бүртгэн, арилжих зөвшөөрлийг олгосон юм.

Дээрх тогтоол болон үнэт цаас гаргагч компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу зохих хяналт шалгалтын ажиллагааг хийсний үндсэн дээр “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 128 тоот тушаалаар “Бинсэ” ХК-ийн нэмж гаргаж буй 1.0 сая ширхэг энгийн хувьцааг хөрөнгийн биржид бүртгэн авч, тус компанийн нийт хувьцааны тоог 2,268,320 ширхэг болгон бүртгэлд өөрчлөлт оруулаад байна.

Компанийн нэмж гаргах 1.0 сая ширхэг хувьцааг дараах байдлаар санал болгон, арилжихыг СЗХ-ноос зөвшөөрөөд байгаа юм. Үүнд:

1. 200,000 ширхэг хувьцааг компанийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Б.Батзаяад хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу хаалттай хүрээнд эзэмшүүлэх,
2. 300,000 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд СЗХ-ны тогтоолын хавсралтанд заасан нэр бүхий 44 хөрөнгө оруулагчид санал болгох,
3. 500,000 ширхэг хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд санал болгож, түүнээс үлдэх хувьцааг олон нийтэд арилжих тус тус орсон байна.

ЗОХИЦУУЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС БУУРСАН ТАЛААР ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ



Дээрх бодлогын арга хэмжээний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4-р сарын 1-ний өдрийн 158 дугаар тогтоолоор “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож, тэдгээрийг төвлөрүүлэх журам”-ыг баталсан бөгөөд мөн 159 дугаар тогтоолоор “Зарим зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөхийг түр зогсоох” тухай шийдвэр гаргасан.

Тус тогтоол, шийдвэрүүдээр үнэт цаасны зах зээлд оролцогчдыг дэмжиж зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараах байдлаар өөрчилсөн байна.

1. Хөрөнгийн биржээс хувьцааны арилжааны шимтгэлийг 0.4 хувиар тооцож авдаг байсныг 0.15 хувь болгон өөрчилсөн.
2. Брокер, дилерийн компанийн хувьцааны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс 0.04 хувиар бодож авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.
3. Брокер, дилерийн компанийн хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцлээс олсон шимтгэлийн орлогоос 10 хувиар бодож авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг мөн 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.
4. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэхэд жил бүр авдаг байсан 2.0 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.
5. Төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үнэт цаасны биржийн арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгээдүүдийн авсан шимтгэлийн орлогоос 10.0 хувийг тооцож авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг мөн 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.
6. Үнэт цаасны арилжаа эрхлэхэд үнэт цаасны биржийн арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгээдүүдийн авсан шимтгэлийн орлогын 10.0 хувийг тооцож авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг мөн 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.

Ингэснээр үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч нар зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 2 жилийн хугацаанд бүрэн чөлөөлөгдөж 358.0 сая төгрөгөөр үйл ажиллагааны зардлаа хэмнэх боломжтой болж байна.

Эх сурвалж: [Санхүүгийн зохицуулах хороо](#)

ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАНА



Монголын хөрөнгийн бирж өөрийн бүртгэлийн журмыг шинэчлэн баталж, Монголд бүртгэлтэй хувьцаат компани гадаад улсад давхар бүртгүүлэх, хувьцаат компанийн бүртгэлийн I, II, III ангилалтай болсноор жижиг дунд бизнес эрхлэгчид хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг нээж өгсөн юм.

4-р сарын 29-өөс 5-р сарын 4-ний өдрүүдийн хооронд МХБ, Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудтай хамтран жижиг дунд бизнес эрхлэгчдэд Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, үнэт цаас гаргах тухай мэргэжлийн зөвлөмж өгөх зорилго бүхий сургалт семинарыг зохион байгуулж байна.

Тус сургалт семинарт Монголын үндэсний үйлдвэрлэгч 10 гаруй компанийн төлөөлөл оролцож байгаа бөгөөд өнөөдөр үнэт цаас гаргах сонирхол бүхий компаниуд өөрийн төсөл болон үйл ажиллагааны танилцуулгыг МХБ-ийн гишүүн андеррайтерийн компаниудад танилцуулж, зөвлөмж авлаа. Цаашид нэр бүхий компаниуд андаррайтерын компаниудтай хамтран ажиллах, үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг эхлүүлэхээр боллоо.

КАСТОИАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗАХ ЗЭЭЛД НЭВТЭРЛЭЭ

Монголын хөрөнгийн бирж Лондонгийн хөрөнгийн бирж групп байгуулсан стратегийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хууль эрх зүй орчныг боловсронгуй болгон өөрчилж, Олон улсын хөрөнгийн зах зээлийн стандарт дэд бүтцийг Монголд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд кастодианы үйл ажиллагаа зах зээлд шинээр нэвтэрлээ.

Өнөөдөр Худалдаа хөгжлийн банк кастодианы үйл ажиллагааг албан ёсоор Монголд анх эхлүүлж буйгаа зарлаж, нээлтийн ёслолын үйл ажиллагааг хийлээ. Тус үйл ажиллагаанд Монголын хөрөнгийн хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Д.Ангар оролцож, Кастодиан банк нь хөрөнгийн зах зээлийн оролцогчдыг холбодог “ГҮҮР” юм гэж тэмдэглэн хэлээд цаашдын ажилд нь амжилт хүслээ. Худалдаа хөгжлийн банкны зүгээс уг үйл ажиллагааг нэвтрүүлэхэд дэмжин ажилласан Монголын хөрөнгийн биржид талархал илэрхийллээ. Монголын хөрөнгийн бирж Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран Кастодианы үйл ажиллагааг нэвтрүүлэхтэй холбоотой ахисан шатны сургалт семинарыг зохион байгуулж, мэргэжлийн дэмжлэгийг үзүүлж ирсэн юм.

Кастодиан банк нь хөрөнгө оруулагчийн мөнгө, хувьцаа, бонд зэрэг үнэт цаасыг найдвартай хадгалах, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай тулгалт хийх, үнэт цаас хүлээн авах, шилжүүлэх, ногдол ашиг болон бусад орлогыг хүлээн авах, байршуулах, үнэт цаас худалдан авсан мөнгийг шилжүүлэх гэсэн үндсэн үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.


Тус банкны үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлснээр хил дамнасан үнэт цаасны арилжаанд оролцох, мэргэжлийн хөрөнгө оруулагчид зэх зээлд нэвтрэх, дотоод руу чиглэсэн валютын урсгалыг нэмэгдүүлэх, мэдээллийн ил, тод байдал сайжрах ач холбогдолтой юм.



5,460 ДАНС ШИНЭЭР НЭЭГДЭЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ИДЭВХ ЭРС НЭМЭГДЖЭЭ

2015 оны эхний 4 сарын байдлаар Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцсон гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжийн арилжааны нийт үнийн дүн 167.2 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс эрс нэмэгдсэн байна.

Мөн арилжааны идэвх нэмэгдэж байгаагийн хэрээр 2015 оны эхнээс 4 сарын 31-ний хүртэлх хугацаанд шинээр 5,460 үнэт цаасны арилжааны данс шинээр нээгдэж, хөрөнгийн зах зээл дээр шинэ тоглогчид нэмэгджээ.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД

“МОНЕТ КАПИТАЛ ҮЦК” ХХК ОНООСОН НЭРЭЭ “АРД СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 24 дугаар тоот тогтоол, “Ард секьюритиз ҮЦК” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн “Монет капитал ҮЦК” ХХК-ийн оноосон нэрийг “Ард секьюритиз ҮЦК” ХХК болгон өөрчлөлт орууллаа.

АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ СЭРГЭЭЛЭЭ

Монголын хөрөнгийн биржийн гишүүнчлэлийн үйлчилгээний өмнөх оны болон 2015 оны 2-р улирлын хөлсөө хуваарийн дагуу бүрэн төлөөгүй нэр бүхий 12 үнэт цаасны компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн түр хязгаарласан билээ.

“Нэйшнл секюритис ҮЦК” ХХК, “Фронтинер ҮЦК” ХХК-иуд гэрээнд заасан үүргээ биелүүлж гишүүнчлэлийн үйлчилгээний хөлсөө төлсөн тул 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс арилжаанд оролцох эрхийг сэргээлээ.

3 ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ СЭРГЭЭЛЭЭ

Монголын хөрөнгийн биржийн гишүүнчлэлийн үйлчилгээний өмнөх оны болон 2015 оны 2-р улирлын хөлсөө хуваарийн дагуу бүрэн төлөөгүй нэр бүхий 12 үнэт цаасны компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн түр хязгаарласан билээ.

"Монгол секюритиес ҮЦК" ХК, "Бумбат-Алтай ҮЦК" ХХК, "Зэт жи би ҮЦК" ХХК-иуд гэрээнд заасан үүргээ биелүүлж гишүүнчлэлийн үйлчилгээний хөлсөө төлсөн тул 2015 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс арилжаанд оролцох эрхийг сэргээлээ.

СЭТГҮҮЛЧИД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААРХ МЭДЛЭГЭЭ ДЭЭШЛҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн бирж нь хөрөнгө оруулагчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор олон талт ажлуудыг хийдэг билээ.

Энэ удаа Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран эдийн засгийн мэргэшсэн сэтгүүлчдэд үнэт цаасны зах зээл, хөрөнгийн биржийн 2015 оны 1 дүгээр улирлын тайлан, арилжаанд хэрхэн оролцох, жижиг дунд бизнес эрхлэгчид хэрхэн үнэт цаасны зах зээлээс хөрөнгө босгох талаар сургалт зохион байгуулж, цаашид хөрөнгө оруулагчдад хэрхэн зөв, бодит мэдээллийг шуурхай түгээх талаар харилцан ярилцлаа.



МХБ АРИЛЖААНЫ ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭГЭЭ БУУРУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар үнэт цаасны арилжааны шимтгэлийн хувь хэмжээг бууруулах шийдвэрийг гаргалаа. Энэхүү шийдвэр баталгаажсанаар хувьцааны арилжааны шимтгэлийн хувь хэмжээ 0.4 хувь байсан нь 0.15 хувь болж буурах юм. Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд тохируулан авч буй энэхүү арга хэмжээ нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалт хийх зардлыг бууруулах, мэргэжлийн байгууллагуудыг дэмжих зорилготой юм.


Дээрх өөрчлөлт нь Монголын хөрөнгийн биржийн арилжааны журамд туссан бөгөөд уг асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооноос батламжилсны дараа хэрэгжүүлж эхэлнэ.

МХБ-ИЙН МОБАЙЛ АППЛЕКЕЙШНЫ 2 ДАХЬ ХУВИЛБАР “APP STORE”-Д ШИНЭЧЛЭГДЭН ТАВИГДАЖ, ХЭРЭГЛЭГДЭХЭД БЭЛЭН БОЛЛОО

Монголын хөрөнгийн бирж нь өдөр тутмын арилжааны болон ханшийн мэдээллийг түгээх гар утас болон хөдөлгөөнт төхөөрөмжид зориулагдсан мобайл апплейшны анхны хувилбарыг 2014 оны 10 дугаарын сарын 24 –ний өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн билээ. Хэрэглэгчдээс ирсэн хүсэлтийн дагуу тус програм хангамжийн 2 дахь хувилбарыг хөгжүүлэн “APP STORE”-д байршууллаа.

Уг шинэчилсэн хувилбар нь МХБ–ийн гишүүн үнэт цаасны компаниудын холбогдох хаяг, удирдлагын мэдээлэл, холбоо барих утас болон хаягийн мэдээллийг нэмж оруулсан бөгөөд мөн хувьцаат компаниудын үнэт цаасны ханшийн өөрчлөлтийг түүхэн графикаар харах боломжийг танд өгч байна.

Шинэчилсэн хувилбар дахь график нь аль нэг брокер, дилерийн компанийн хувьцааны симбол дээр дарсанаар харагдах ба энэ нь хөдөлгөөнт төхөөрөмжийн хэвтээ байрлалд бүтэн дэлгэцийн горимд ажиллах чадвартай. Түүнчлэн энэхүү график нь 10 өдрөөс 5 жил хүртэл, цаашлаад бүх түүхэн мэдээллээр харагдах ба тухайн өдрийн үзүүлэлтийг муруйн дагуу даран гүйлгэх замаар хялбархан харах боломжтой юм.



ЖАЙКА ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГАТАЙ УУЛЗАЛТ, СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголын хөрөнгийн бирж Япон Улсын Засгийн газрын Жайка олон улсын байгууллагатай хамтран өөрийгөө зохицуулах байгууллага бий болгох талаар уулзалт семинарыг зохион байгууллаа.

Уг уулзалт семинарт МХБ-ийн Гүйцэтгэх захирал Д.Ангар өөрийгөө зохицуулах байгууллага болохын ач холбогдол, МХБ-ын бодлого чиглэлийн талаар танилцуулга, Жайкагийн төслийн багаас өөрийгөө зохицуулах байгууллагын олон улсын жишиг, олон улсын үнэт цаасны хороонд тавьдаг стандарт болон бусад асуудлаар Монголын хөрөнгийн биржийн ТӨХК-ын ТУЗ-ийн гишүүдэд танилцуулга хийж, харилцан санал солилцлоо.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар Хөрөнгийн бирж, Арилжааны тооцооны болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Арилжаа эрхлэгчдийн холбоо гэсэн дөрвөн байгууллага нь өөрийгөө зохицуулах байгууллага байхаар заасан байдаг бөгөөд Өөрийгөө зохицуулдаг байгууллага болсноор Санхүүгийн зохицуулах хорооны зарим нэг чиг үүрэг тухайн байгууллагад шилжинэ гэсэн үг. Тодруулбал, өөрийн гэсэн дүрэм журамтай, гишүүн байгууллагуудтайгаа ёс зүйн дүрэм боловсруулах, зах зээлийг ил тод шударга, нээлттэй явуулах олон улсын стандартуудыг нэвтрүүлэх зэрэг ач холбогдолтой юм.



МОНГОЛ УЛСЫН ГУРВАН САЯ ДАХЬ ИРГЭН Х.МОНГОЛЖИН ОХИН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАМГИЙН ЗАЛУУ ТОГЛОГЧ БОЛЛОО



Монгол улсын гурван сая дахь иргэн Х.Монголжин охины аав Э.Хатанболд Монголын хөрөнгийн биржээр зочилж, Засгийн газрын үнэт цаас худалдан авах эрхийн бичгээ гардан авч Ард Секьюритиз ҮЦК дээр үнэт цаасны данс нээлгэж, тус компанийн

харилцагч болсноор Монгол улсын гурван сая дахь иргэн Х.Монголжин охин хөрөнгийн зах зээлийн хамгийн залуу тоглогч боллоо.

Дашрамд дурдахад Монголын хөрөнгийн биржээс 2 дугаар сард зохион байгуулсан Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг арга хэмжээний үеэр Ард санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг Монгол улсын гурван сая дахь иргэн Х.Монголжин охинд сая төгрөгийн ЗГҮЦ эзэмшүүлэхээр болсон юм. Мөн Олимпын аварга хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин Э.Бадар-Ууган үнэт цаасны данс нээлгэн хөрөнгийн зах зээлийн тоглогч болохоо илэрхийлсэн билээ.

“ТАВАН ТОЛГОЙ” ХК ЗӨВЛӨМЖИЙГ ХҮЛЭЭН АВЧЭЭ

Монголын Хөрөнгийн биржээс Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Компанийн засаглалыг дэмжих нэгжийг байгуулан ажиллаж байгаа билээ. Тус нэгжээс “Жилийн үйл ажиллагааны тайлан бэлтгэх тухай” болон “ХК өөрийн цахим хуудсанд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд зориулсан булантай байх” тухай зөвлөмжийг гарган ХК-иудад хүргүүлсэн.

Энэ дагуу МХБ-ийн ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлэгч хувьцаат компаниудаас хамгийн түрүүнд “Таван толгой” ХК-иас дээрх зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар мэдэгдэл ирүүллээ. МХБ-ийн санаачлагыг дэмжиж, Компанийн сайн засаглалын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахаа мэдэгдсэн “Таван толгой” ХК-д нийт хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын өмнөөс талархал илэрхийлье.

Биржид бүртгэлтэй нийт ХК-иуд “Таван толгой” ХК-ийн үлгэр дууриаллаар энэхүү зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг уриалж байна.

Д.АНГАР: ЭРДЭНЭТ ХОТОД НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛНА

Урин дулаан цагтай уралдан нүүрээ угааж байгаа Хөрөнгийн биржээр ойрд сонин сайхан юу байгаа талаар Монголын Хөрөнгийн Бирж /МХБ/-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангартай ярилцлаа.

-Хөрөнгийн биржээр сонин сайхан юу байгаа талаар ярилцлага эхлэх үү?

-Бидний хувьд хийж байгаа болон шинээр эхлүүлсэн ажлууд маань сонин байх болов уу. Хөрөнгийн бирж өнгөрсөн хугацаанд Нээлттэй хаалганы өдрийг нийслэлд зохион байгуулж ирсэн. Хүмүүст ч их хүрдэг. Энэ оны хоёрдугаар сард зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрөөр гэхэд л бид 6500 орчим хүнд үйлчилсэн байх жишээтэй. Эндээс иргэд хөрөнгийн зах зээлийг сонирхож харагдаж байна. Тиймээс бид орон нутагт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулахаар төлөвлөөд байгаа юм. Эхний удаа Орхон аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран Эрдэнэтэд ирэх сарын 3-нд нээлттэй өдөрлөг зохион байгуулахаар болсон.

-Тэнд ямар асуудал яригдах вэ?

-Хөрөнгийн бирж жижиг дунд үйлдвэрлэлээ дэмжихэд анхаарч байна. Энэ хүрээнд ч их ажил хийлээ. Тухайлбал, тэдэнд Хөрөнгийн бирж дээрээс хөрөнгө оруулалт татах таатай боломжийг бүрдүүлэхийн тулд хууль эрх зүй, цаг хугацаа, зардал мөнгөний хувьд аль алийг нь харьцангуй таатай болгож өглөө. Үүнтэй холбоотой Хөрөнгийн бирж рүү орж ирэх компаниудын тоо ч нэмэгдэж байна. Үүнийг нэг жишээ нь Бинсэ юм. “Бинсэ” компанийн талаарх мэдээллийг <http://mse.mn/videonews/show/newsid/57> линкээс авна уу.



Тэгэхээр бид орон нутагт байгаа бизнес эрхлэгчдэд Хөрөнгийн биржээс хөрөнгө оруулалт татах ямар таатай боломж байгааг тайлбарлана. Дараагийн нэг том ажил бол иргэд олон нийтэд хөрөнгийн зах зээлтэй холбоотой олон асуулт байдаг. Тухайлбал, нөгөө л цэнхэр, ягаан тасалбарын асуудал.

Тиймээс орон нутгийн иргэдэд хөрөнгийн зах зээлийн мэдээллийг өгөх нь чухал. Төрийн өмчит томоохон компаниудын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг Засгийн газрын үнэт цаасанд оруулах замаар үндсэн үйл ажиллагаанаасаа гадуур орлого олох боломжийг бүрдүүлэх зорилготой танилцуулга хийж байгаа. Одоогийн байдлаар ДЦС 3, МИАТ зэрэг компаниудад танилцуулга хийгээд байна. Яг үүнтэй адилхан орон нутгийн

иргэд, аж ахуй нэгжүүдэд Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулаад өндөр өгөөж хүртэх боломж байгааг тайлбарлаж өгөх юм. За тэгээд тухайн компани өөрсдөө бонд гаргаж болно. Заавал компаниас өндөр хүүтэй зээл авах эсвэл хувьцаа гаргахгүй бонд гаргаж болохыг компаниудад тайлбарлах нь зүйтэй. Дээрээс нь орон нутгийн засаг захиргаа бонд гаргах хууль эрх зүйн орчин нь бүрдчихсэн байдаг. Одоогийн байдлаар орон нутагт татаас авдаг гурван аймаг байгаа. Тэр нь Дархан, Орхон буюу Эрдэнэт, Өмнөговь. Тэгэхээр эдгээр аймаг бонд гаргах боломжтой. Гэхдээ Өрийн удирдлагын тухай хууль юу болж байгаа бол.

-Орхон аймгийн бизнес эрхлэгчид Хөрөнгийн биржийн талаар хэр мэдээлэлтэй байгаа бол?

-Орхон аймгийн компаниудын хувьд нэлээд хүлээлттэй байгаа юм билээ. Тиймээс бид ямар боломж байгааг тэдэнд танилцуулах юм. Харин компаниуд тэр боломжийг ашиглах эсэх нь тэдний асуудал. Ер нь Хөрөнгийн бирж олон зүйл хийж байгаа. Түүнийгээ зах зээлд таниулах нь чухал болоод байна. Энгийн жишээ гэхэд л арилжааны шимтгэл буюу хоёрдагч зах зээл дээр өдөр бүр явж байгаа арилжааны шимтгэлээ бид бууруулсан. Өмнө нь 0.4 хувийн шимтгэл авдаг байсан бол одоо 0.15 буюу 60 хувиар бууруулсан. Төлбөр тооцоог гурав хоног гүйцэтгэдэг байсан бол одоо нэг хоног болсон. Цаг хугацаа гэдэг өөрөө мөнгө. Тэгэхээр та өнөөдөр хувьцаа авсан бол маргааш гэхэд л мөнгө нь шилждэг Т1 горимд шилжсэн гэсэн үг. За дээрээс нь дөнгөж орж ирж байгаа компаниудыг МХБ 60 хоног бүртгэдэг байсан бол одоо 20 хоног болсон. Нэг удаагийн буюу бүртгүүлэх зардал болон нийт арилжсан үнийн дүнгээс нь авдаг зардлуудыг ч мөн бууруулсан.

-Сүүлд хэлсэн зардлын хэмжээ ойролцоогоор хэдэн хувь буурч байгаа вэ?

-40 орчим хувиар буурсан.

-Сүүлийн үед Хөрөнгийн бирж олон нийтэд мэдээлэл өгөхөд түлхүү анхаарч байна. Уг нь та нарын гол үүрэг бол арилжаа зохион байгуулах биз дээ?

-Хөрөнгийн бирж арилжаа зохион байгуулдаг байгууллага ч гэсэн бид нар зах зээлд оролцдог гол байгууллаг учраас өөрсдөө манлайлаад ямар боломж байгааг олон нийтэд мэдээлэл өгөх учиртай. Учир нь энэ зах зээл өөрөө мэдээлэл дээр тулгууралдаг юм. Тэгэхээр хөрөнгийн зах зээл хөгжихгүй байгаагийн нэг шалтгаан нь мэдээлэл дутмагтай холбоотой. Бидний хувьд ийм ийм боломж байна гэдгийг олон нийтэд хэлж, замыг нь нээж өгөх гээд байгаа юм. Тэгэхгүй бол бүх төлбөр тооцоо, зээл хэдхэн арилжааны банкаар явж, ажил хийдэг нь цалингийн, хөгшид нь тэтгэвэрийн, аж ахуй нэгж нь хөрөнгө оруулалтын гээд бүгдээрээ шахуу банкны зээлтэй байна. Ийм нөхцөлд ганцхан том арилжааны банк дампуурахад л улсын эдийн засаг элгээрээ хэвтэнэ. Тэгэхээр хөрөнгийн зах зээлийг зайлшгүй хөгжүүлэх шаардлагатай. Тиймээс л бид мэдээлэл өгөхөд түлхүү анхаарч байна даа.

-Манай нөхцөлд үйл ажиллагаагаа дөнгөж эхлүүлж, анхны хөрөнгө оруулалтаа олох гэсэн компаниуд л банкны үүд сахиж ихэнх нь өндөр босгонд нь бүдэрдэг. Нэгэнт төлөвшсөн томууд нь гадна дотны Хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах учраа олчихсон байдаг. Тэгвэл тэр учраа олоогүй хэсэгт Хөрөнгийн бирж дээр гарах боломж байна уу?

-Бид бизнес эрхлэгчдэд тавьдаг өндөр босгыг бууруулсан. Өмнө нь хоёрхон самбартай байхад үндсэн хөрөнгө нь доод тал нь нэг тэрбум, дээд тал нь 10 тэрбум байх ёстой. Мөн үйл ажиллагаа явуулсан жил нь гурван жил байх ёстой гэдэг байсан. Ингэхээр иргэдийн дунд Хөрөнгийн бирж бол бидний биш том компаниуд л ордог газар гэх буруу ойлголт бий болчихсон байсан нь үнэн. Тэгвэл одоо гурав дахь самбартай болсноор тэнд гарааны компани ч орж ирэх боломжтой болж байгаа юм. Тэндээс хөрөнгө оруулагчид үнэхээр ашигтай төсөл байвал хөрөнгөө оруулаад л явчихаж болно гэсэн үг.

-Ийм болчихоор хөрөнгө оруулагчид өндөр эрсдэл үүрэх юм биш үү?

-Ингэлээ гээд хөрөнгө оруулагчдыг хохироохгүй. Босго багасч байгаа бол шаардлага улам чанарах учиртай. Адаглаад өнөөх мэдээллийн ил тод байдлыг нь бий болгох жишээтэй. Өнгөрсөн долоо хоногт Хөрөнгийн бирж компанийн засаглалын нэгжтэй боллоо. Энэ хүрээнд ТОП 20 компанитайгаа гэрээ байгуулаад мэдээллийг нь ил тод байлгахад анхаарч байна. Адаглаад Хөрөнгийн биржээс хөндлөнгийн хянагч ТУЗ-ийн хуралд нь суух жишээтэй. Хөндлөнгийн хянагчийн хувьд тухайн компанийн хөрөнгө санхүүгийн тайлан үнэн зөв байлгах болон мэдээллийг хөрөнгө оруулагчдад цаг тухайд нь өгч байгаа эсэхэд шаардлага тавих юм. Ингээд ирэхээр Хөрөнгийн биржийн бодлого илүү цогц болж байна гэж ойлгож болно. Дээрээс нь бид зүгээр нэг шаардаад байх биш өөрсдөө бүх мэдээллээ дэлгэрэнгүй өгч байна.

Тийм ч болохоор Авилгатай тэмцэх газраас өгдөг Сайн засаглал бүхий компанийн өргөмжлөлийг Төрийн өмчит компаниудаасаа ганцхан манайх авсан.

Өнөөдөр бид ажилчдынхаа цалинг хүртэл цахим хуудастаа мэдээлж байна. Орлого зарлагаа хүртэл нэг ч төгрөгийн зөрүүгүй мэдээлж байгаа. Товчхондоо Хөрөнгийн биржид нуугаад байх зүйл байхгүй гэсэн үг.

-Нэг талаасаа компаниуд хөрөнгийн бирж дээр гарах таатай боломж нь бүрдсэн байна. Гэхдээ нөгөө талаасаа хөрөнгө оруулагчдын хувьд хэр хүлээлтэй байгаа бол. Мөн тэр хөрөнгө оруулагчдын чадамжийг та юу гэж харж байна вэ?

-Банкинд хадгалагдаж буй хөрөнгийн хэмжээ 7.8 их наяд төгрөг байна. Энэ бол санхүүгийн зах зээлд эргэлдэж байгаа бэлэн мөнгө. Энэ мөнгийг хаашаа хөрөнгө оруулалт хийх вэ гэдэг нь тухайн бүтээгдэхүүнээс шалтгаална. Тухайлбал, Засгийн газрын бонд гээд сайн бүтээгдэхүүн зах зээлд гараад ирэхээр 235 тэрбум төгрөгийг арилжчихсан байна. Тэгэхээр зах зээлд байгаа мөнгөний тодорхой хувь нь ийшээ орсон гэсэн үг. Эндээс юу харагдаж байна гэхээр хэрвээ ашигтай үнэт цаас байвал хөрөнгө оруулагчид орж ирэх нь ойлгомжтой байна. Өнөөдөр банкнаас хөрөнгө оруулалт татах гэхээр хүндрэлтэй байна. Адаглаад 888 төслөөс 156 нь л санхүүжилт авчээ. Үүний шалтгаан нь банкны шалгуур өндөр, барьцаа хөрөнгө шаарддаг. Мөн одоогийн байдлаар банкуудын хөрөнгийн хэмжээ багасчихсан байдалтай байгаатай холбоотой.

Тэгэхээр яг одоо л Хөрөнгийн бирж дээрээс хөрөнгө оруулалт татдаг, ийшээ хөрөнгө оруулагчид хөрөнгөө оруулдаг цаг юм. Нөгөө талдаа хувьцаа ч бараа, орон сууц ч бараа. Өнөөдөр орон сууц хямдарлаа гээд мөнгөтэй нэг нь худалдаж аваад дараа нь үнэд орохоор нь зарна гэж байна. Яг үүнтэй адилхан өнөөдөр анх хувьцаа гаргаж байгаа компаниудын хувьцаа хавьгүй хямдхан

байгаа. Гэхдээ урт хугацаандаа үнэд орно. Энэ зах зээл угаасаа урт хугацаандаа ашгаа өгдөг болохоор одоо л хувьцаа авдаг цаг гэдгийг дахин хэлмээр байна.

-Түрүүн та цухас дурдаад өнгөрсөн Төрийн өмчит компани /ТӨК/-д хийж байгаа танилцуулгынхаа талаар дэлгэрэнгүй тайлбарлахгүй юу?

-Засгийн газрын бонд бол ижил хугацаатай арилжааны хадгаламжийн хүүнээс 0.2-0.4 хувийн өндөр хүүтэй байгаа. Нөгөө талдаа ТӨК-иудын харилцах дансны буюу чөлөөт үлдэгдлийг зүгээр байлгаж байхаар өндөр өгөөжтэй Засгийн газрын бондод хөрөнгө оруулаачээ гэдэг санал тавьж байгаа юм. Энэ нь аль аль талдаа ашигтай.

-Уучлаарай Хөрөнгийн бирж ингээд л энэ тэнд очоод Брокерийн ч ажил хийгээд Кастионы банкны ч ажил хийгээд. Бүр өөрсдөө хувьцаа авсан байна билээ. Ингээд яваад байх нь зөв үү?

- Хөрөнгийн бирж өөрсдөө 500 сая төгрөгийн бонд авсан. Эндээсээ ашгаа увуулж цувуулж авсаар ойролцоогоор 25 сая төгрөг олчихсон байна. Энэ мөнгөөрөө бид биржийнхээ гадна талыг засч байх жишээтэй. Энэ бол нэг талдаа бусдад хувьцаа авбал ийм ашигтай байдаг юм байна шүү гэсэн үлгэр дууриалал гэж ойлгож болно. Өнөөдөр Хөрөнгийн биржийг хөгжүүлэх шаардлага байна уу байна. Гэтэл ийшээ

хэн ч ойртохгүй байгаа өнөөгийн үед бид өөрсдөө бүхний түрүүнд явах манлайлах, уриалах шаардлагатай. Тиймээс л Хөрөнгийн бирж энэ зах зээлийг хөгжүүлэхийн тулд өөрсдөө манлайлж байна л даа. Нэг талаасаа хүмүүс Хөрөнгийн бирж Засгийн газрын бонд зарж байна гэх байх. Гэхдээ өмнө нь нэг бүрийн үнэ нь сая төгрөгийн үнэтэй үнэт цаасыг том банкуудад л хаалттай арилжаад зөвхөн тэд л ашиг хүртдэг байсан.

Харин энэ удаа Хөрөнгийн биржээр дамжиж олон нийт ашиг хүртэх боломж нь нээлттэй болсонд л хамаг учир нь байгаа юм. Одоогийн байдлаар бид 7.9 тэрбумын өгөөжийг өгөхөөр байна. Тэгэхээр одоо зөвхөн банкны хадгаламжинд мөнгөө хадгалуулах биш 100 хувь эрсдэлгүй Засгийн газрын бондод санхүүжүүлэх боломжтой болж байгаа юм. Эндээс Хөрөнгийн бирж шимтгэл ч аваад шалиагүй. Ердөө нийт арилжааны 0.00875 хувийг нь л арилжааны шимтгэл болгож авдаг. Харин Засгийн газрын үнэт цаас авч байгаа хөрөнгө оруулагч тал Хүн амын орлогын албан татвараас чөлөөлөгдөж байх жишээтэй. Тэгэхээр энэ бол зах зээлээ хөгжүүлэх, тэдэнд өгөөж өгч байгаа ажил юм.

**Э.Зоригт
Эх сурвалж:**

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2015 оны 5 дугаар сарын 25-ноос 5 дугаар сарын 29-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



ӨДРИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2015 оны 05 дугаар сар

Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	1,099,931
Нийт үнийн дүн /төг/	29,499,092,201.30
Хэлцлийн тоо	942
Арилжигдсан үнэт цаасны тоо	63
Зах зээлийн үнэлгээ /төг/	1,253,898,741,087

ТОП-20 индекс

Хаалт	12,756.58
Өөрчлөлт /%/	-2.49

MSE ALL индекс

Хаалт	921.67
Өөрчлөлт /%/	-3.18



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	MRX	МЕРЕКС	490,523	1	APU	АПУ	100,736,867
2	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	175,413	2	MRX	МЕРЕКС	43,210,935
3	RMC	РЕМИКОН	32,415	3	GOV	ГОВЬ	42,485,665
4	APU	АПУ	28,930	4	TCK	ТАЛХ ЧИХЭР	36,645,030
5	JTB	Ж БНКО ТУР БЮРО	19,469	5	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	24,394,663

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	TEX	ТЕХНИК ИМПОРТ	919.13		32.25
2	AOI	АВТО ИМПЕКС	3,680.00		11.52
3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	3,717.00		9.29
4	SUL	ГАЗАР СҮЛЖМЭЛ	53,000.00		6.00
5	MVO	МОНГОЛ ШЕВРО	2,530.00		5.42

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	HGN	ХӨХ ГАН	70.00		-25.53
2	NXE	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	1,200.00		-20.00
3	UYN	МОНГОЛ САВХИ	800.00		-15.88
4	BDL	МОГОЙН ГОЛ	6,800.00		-15.00
5	BTG	БАЯНТЭЭГ	18,600.00		-14.99

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-12-304	30,523	2,950,658,410	96,670	12	14.967
2	ЗГЭБ-Б-28-305	2,437	224,942,411	92,303	28	15.529
3	ЗГЭБ-У-156-306	185	18,500,000	100,000	156	16.875
4	ЗГХБ-Б-12-307	255,304	24,684,067,240	96,685	12	14.90
5	ЗГЭБ-Б-52-308	6,709	670,900,000	100,000	52	15.75
6	ЗГЭБ-У-156-309	141	14,100,000	100,000	156	16.875

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ZGEB-BD-28/04/16-A0029-16	51	5,100,000	100,000	52	16
2	ZGEB-BD-28/04/16-A0029-16	10	1,000,000	100,000	52	16
3	ZGEB-BL-30/06/15-A0023-0	6	581,280	96,880	12	15.185
4	ZGEB-BL-28/07/15-A0031-0	20	1,933,400	96,670	12	14.967
5	ZGEB-BL-02/06/15-A0019-0	10	995,000	99,500	12	15.54
6	ZGEB-BL-02/06/15-A0019-0	10	997,000	99,700	12	15.54
7	ZGEB-BL-19/05/15-A0016-0	100	9,976,000	99,760	12	15.019
8	ZGEB-BL-02/06/15-A0019-0	3,326	329,939,200	99,200	12	15.54
9	ZGEB-BD-01/03/16-A0017-16.625	1	100,010	100,010	52	16.625
10	ZGEB-BD-01/03/16-A0017-16.625	69	6,900,690	100,010	52	16.625
11	ZGEB-BD-26/05/16-A0035-15.75	30	2,996,100	99,870	52	15.75
12	ZGEB-BL-10/07/15-A0028-0	10	984,000	98,400	12	14.988
13	ZGEB-BL-10/07/15-A0027-0	11	1,082,400	98,400	12	14.988
14	ZGEB-BL-10/07/15-A0027-0	2,242	219,917,780	98,090	12	14.988